

УВС АЙМГИЙН 2017 ОНЫ ЭХНИЙ 9 САРЫН ЭРҮҮ, ХЭВ ЖУРМЫН НӨХЦӨЛ БАЙДЛЫН ТАНИЛЦУУЛГА

2017.10.01

Улаангом сум

Нэг. ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН ТАЛААРХИ ГОМДОЛ, МЭДЭЭЛЭЛ

Увс аймгийн цагдаагийн газарт 2017 оны 01 дүгээр сарын 01-ны өдрөөс 2017 оны 09 дүгээр сарын 25-ны өдөр хүртэлх хугацаанд иргэд, аж ахуй нэгж, байгууллагаас гэмт хэргийн шинжтэй 539, зөрчлийн шинжтэй 1256, нийт-1759 гомдол, мэдээлэл хүлээн авсан нь өмнөх оны мөн үеэс -693 нэгжээр буюу -28.2 хувиар буурсан байна.

Гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээлэл өмнөх оны мөн үетэй харьцуулахад -158 нэгжээр буюу -22.6 хувиар буурсан байна.

Хүлээн авсан гомдол мэдээллийн 277 гомдол мэдээлэлд эрүүгийн хэрэг үүсгэж, 250 гомдол мэдээллийг эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах саналтай Прокурорын хяналтанд хүргүүлж шийдвэрлэсэн.

Захиргааны зөрчлийн шинжтэй 728 гомдол мэдээлд ердийн журмаар торгож, 193 гомдол мэдээлэлд зөрчлийн хэрэг нээж, 107 гомдол мэдээллийг шүүхээр 7-30 хоногоор баривчилж, 202 гомдол мэдээллийг тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасаж торгож, 65 гомдол мэдээллийг зөрчлийн хэрэг нээхээс татгалсан байна

Архидан согтуурч захиргааны зөрчил гаргасан 642 хүнийг саатуулсан нь +45 нэгжээр өссөн байна.

Торгуулийн хуудсаар, бэлэн бус торгуулиар 5377 зөрчилд 180.813.300 төгрөгний торгууль, шийтгэврийн хуудсаар 1129 зөрчилд 134.016.000 төгрөгний торгууль ногдуулсан.

Хоёр. БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ

Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг: Аймгийн хэмжээнд **265** гэмт хэрэг бүртгэгдсэн, өмнөх оны мөн үеэс **+28 хэргээр буюу +11.8 хувиар өссөн байна.**

- Аймгийн хэмжээнд гэмт хэргийн илрүүлэлт 59.1 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс -15.5 хувиар буурсан байна.

Хэрэг бүртгэлтийн хэрэг-198, мөрдөн байцаалтийн хэрэг-67

Хялбаршуулсан журмаар 83 хэрэгт хэрэг бүртгэлтийн ажиллагаа явуулсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 15 хэргээр буюу 22.0 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Гэмт хэргийн гаралт нутаг дэвсгэрээр:

-145 хэрэг буюу 54.7 хувь нь бусад суманд

-120 хэрэг буюу 45.2 хувь нь Улаангом сумдын нутаг дэвсгэрт бүртгэгдсэн

Гарсан гаригаар нь авч үзвэл:

-Даваа-43

-Мягмар-38

-Лхагва-40

-Пүрэв-41

-Баасан-35

-Бямба-33

-Ням-35

Гэмт хэргийг гарсан цагаар нь авч үзвэл:

-06-14 цагт -58

-14-19 цагт-67

-19-22 цагт-42

-22-06 цагт-98 тус тус үйлдэгдсэн байна.

Гэмт хэргийн улмаас :

Иргэн, аж ахуй нэгж байгууллагад учирсан 309.200.000 төгрөгний хохиролын 254.000.000 төгрөгний хохиролыг хэрэг бүртгэлт мөрдөн байцаалтын шатанд төлүүлж, хохирол нөхөн төлүүлэлтийн хувь нь 82.2 буюу өмнөх оны мөн үетэй харьцуулахад -1.2

хувиар буурсан байна. Иргэд аж ахуй нэгж байгууллагаас 242.200.000 төгрөгний хохирол битүүмжилж ажилласан.

Үйлдэгдсэн гэмт хэргийг төрлөөр нь авч үзвэл:

- хүнийг санаатай алах-1
- Бусдыг амиа хорлоход хүргэх гэмт хэрэг -5
- Бусдын бие махбодид гэмтэл учруулах гэмт хэрэг-116
- Танхайрах гэмт хэрэг-2
- Хүчиндэх-7
- Иргэдийн өмчийн хулгай-39
- Малын хулгай -42
- Тээврийн хэрэгслийн хулгай-3
- Залилан мэхлэх-1
- Завших, үрэгдүүлэх-2
- ТХХАБЖЭГХ / 215 / -11
- БХЖЭГХ-4
- Гээгдэл эд зүйл, мал ашиглах-13
- Бусдын эд хөрөнгө санаатай устгаж гэмтээх гэмт хэрэг-1
- Үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг-1
- Бусад-17 гэмт хэрэг тус тус бүртгэгдсэн байна.

Хулгайн хэргийн 42 буюу 50.0 хувийг мал хулгайлах хэрэг эзэлж байгаа ба өмнөх оны мөн үетэй харьцуулахад +24 хэргээр буюу +133.3 хувиар өссөн. Иргэдийн өмчийн хулгайн гэмт хэрэг 39 байгаа нь өмнөх оноос -8 хэргээр буюу -17.0 хувь буурсан.

Бусдын бие махбодид гэмтэл учруулах гэмт хэрэг 18 нэгжээр буюу 18.3 хувиар, хүчиндэх гэмт хэрэг 4 нэгжээр буюу +133.3 хувиар тус тус өссөн байна.

Бүртгэгдсэн гэмт хэргүүдийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулж үзвэл, согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг +3 нэгжээр, гудамж талбайд үйлдэгдсэн гэмт хэрэг +3 нэгжээр, гэр орон сууц +19 нэгжээр, гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг +9 нэгжээр тус тус өсч бүлэглэн гүйцэтгэсэн гэмт хэрэг-8, эмэгтэй хүн оролцож үйлдэгдсэн гэмт хэрэг -6 нэгжээр, хүүхэд оролцсон гэмт хэрэг -3 нэгжээр тус тус буурсан байна.

ТАНИЛЦУУЛГА БИЧСЭН: МЭДЭЭЛЭЛ СУДАЛГААНЫ МЭРГЭЖИЛТЭН,
ЦАГДААГИЙН АХМАД М.ОДХҮҮ